



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/430.

Булган сум

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн өдөр
зарим үйл ажиллагааг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулагдахтай холбогдуулан нөхөн сонгуультай сумдад 2025 оны 06 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг тус тус хориглосугай.

2. Захирамжийг аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР